

Үндсэн хуульд өөрчлөлт оруулах эхний алхам

Бүхэлд нь өөрчлөх, эсэх нь одоогоор тодорхойгүй байна. > 2

Монголчуудыг дэлхий "Хуц" гэв-2

Монголд хувийн өмч рүү гэв гэнэт халдлаа гэсэн шуугиан голлож байна. > 4

"Rio Tinto" Монгол Улсад 215 сая ам.долларын татвар төлжээ

2016 онд дэлхийн хэмжээнд нийт 5.3 тэрбум ам.долларын татвар төлжээ. > 11



МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.04.11, МЯГМАР ~ №066 (612)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Элчин сайд Б.Дэлгэрмаа ОУХОБ-ны дарга Н.Н.Косовад Сангийн сайдын захидлыг хүргэв. **УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан** нарын гишүүд офшорын эсрэг лобби бүлэг байгуулжээ. **Намын бүлгүүд төсвийн** тодотголын талаар мэдээлэл сонсов. **Нийслэлийн АН-ын дарга** Д.Баттулга өчигдөр тамга, тэмдгээ гардаж авав. **ЕХ-ны дэргэд суух Элчин сайд** О.Оч Дональд Тускэд итгэмжлэх жуух бичгээ өргөн барив.

ЭДИЙН ЗАСАГ

Банк хоорондын валют арилжааны цахим талбарын үйл ажиллагаа эхэллээ. **Монголбанкны нэг долоо** хоногтой үнэт цаасны үлдэгдэл нэг их наяд төгрөгт хүрэв. **Хөрөнгийн биржийн арилжааны** индекс 838.97 нэгж болж, 0.28 хувиар буурав. **БНХАУ-ын эдийн засгийн** өсөлт энэ онд 6.5, ирэх онд 6.2 хувиар өсөх төлөвтэй байна. **АНУ-ын ажилгүйдлийн** түвшин 4.5 хувь болж буурав.

НИЙГЭМ

19-35 насны дөрвөн иргэн хар тамхи хэрэглэж байсныг цагдаагийнхан илрүүлжээ. **Дундговь аймгийн хоёр сум** яаралтай тусламжийн шинэ машинтай болно. **Арванхоёрдугаар ангийн хоёр** охин байшин дээрээс үсэрсч амиа хорлосон хэрэг гарчээ. **Хуурайшилтын улирал эхэлсэн** тул түймрээс сэргийлэх хяналтыг чангатгахаар боллоо. **"Жи тайм" сүлжээний** хохирогчдын тоо 10 мянга гаруй болсон талаар мэдээлэв.

ДЭЛХИЙ

АНУ-ын Ерөнхийлөгч асан Б.Клинтон том Бушийг эргэжээр очихдоо оймс бэлэглэжээ. **Британийн Гадаад хэргийн** сайд Сирид дахин цохилт өгөх боломжийг үгүйсгэсэнгүй. **Унгарт Соросын их сургуулийг** хаахаас сэргийлж, 700 мянга орчим хүн жагслаа. **Хойд Солонгос руу илгээсэн** АНУ-ын байлдааны хөлгүүд Өмнөд Солонгосыг чиглэв. **Хятадын даатгалын зохицуулах** комиссын даргыг авлигад сэжиглэн байцааж байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.04.11



Ургадаг "уурхай"



Урд хөршөөс жимс жимсгэнэ, нарийн ногоо худалдан авахад жилд зарцуулж буй 20 сая ам.долларыг дөрвөн улирлын хүлэмжийн хүчээр эх орондоо шингээнэ. ▶11

Төрийн тансаглалыг зогсоох шахалтыг баялаг бүтээгчид эхлүүлээ

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Эдийн засгийн энэ эгзэгтэй үед төр хар амиа бодлоо. Тэд ачааны хүндийг ард түмэндээ үүрүүлэхээр шийдэж. Тэвчиж болох зардлаа ч танаж чадсангүй. Харин долоон төрлийн татварыг нэмэх төсвийн тодотголыг УИХ хэлэлцэхээр хүлээгдэж байна. Төсвийнхөө үрэлгэн зардлаа хумиад хямралыг давахын оронд татвараа нэмэх хувилбарыг эцэст нь сонгожээ. Энэ бол төр хэтэрхий төмөр нүүрээ харуулсан хэрэг болов. Ийнхүү хаврын

чуулганы хамгийн халгаатай сэдэв нь 2017 оны төсвийн тодотгол болж байна. Тодотгол тодрох болсон шалтгаан нь иргэн болгоны халаасыг тэмтэрч байгаа болохоор, тэр. Эрх баригчид иргэдийнхээ амьдралыг анзаарсан бол өнөөдөр албан тушаалынхаа тансаглалыг авч үлдэхгүй байх байлаа. Өрхийн төсөв рүү өнгөрсөн төсөл боловсруулах ч үгүй байсан. Төсвийн тодотголоор зардлыг 220.7 тэрбум төгрөгөөр нэмсэн төслийг УИХ одоо хэлэлцэж байна.

▶3

Пентагон Солонгосын хойгт хүчээ зузаатгана

Деметри Севастополо, Том Митчелл

АНУ Сири дэх дайралтынхаа дараа Пхеньянд хүчээ харуулахаар шийдэв бололтой. Пуужин харваснаас хэдхэн цагийн хойно Цагаан ордон энэ цохилт Арабын улс төдийгүй бүх дэлхийд дохио болох ёстой гэж мэдэгдсэн. Хойд Солонгосын удирдагч Ким Жон Ун хэд хэдэн удаа пуужингийн туршилт хийснийг Вашингтон өдөөн хатгалга гэж үзсэн билээ. Пхеньян Сирид өгсөн цохилтыг эрс шүүмжлээд "Хүлцэж болшгүй түрэмгий үйлдэл" хэмээн нэрлэж, цөмийн зэвсгээ сайжруулах шаардлагыг нэмэгдүүллээ гэсэн юм.


Үүний сацуу Пентагон Солонгосын хойгт байлдааны онгоц

тээгч хөлгөө байрлуулахаар шийдвэрлэсэн талаар АНУ-ын цэргийн өндөр тушаалтан манай сонинд ярихдаа дээрх арга хэмжээг "хүчээ харуулах явдал" гэжээ. Түүнчлэн Хятад улс уг цохилтыг анхааралдаа авсан байх.

Учир нь Сирийн агаарын баазыг довтлох үед АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Хятадын Ерөнхийлөгч Ши Жинпинтэй зоог барьж байсан билээ. Хойд Солонгосын талаар Трампын засаг захиргаа хатуу мэдэгдэл хийсний улмаас Хятадад түгшүүр үүсээд байсан нь саяын цохилтоос бүр ч нэмэгдсэн байж болох.

▶9

ЗГМ: ИНФОГРАФИК



ЗГМ: СЭДЭВ Эко барилгын эрин Нураах шаардлагатай барилгын тоо 2027 он гэхэд хоёр дахин нэмэгдэнэ

З.Цэлмэг
@tselmegZGM

Хотжиж эхлээд хагас зуун жил гаруйг элээгээд буй Улаанбаатарынханд тулгарч сорилт дундрах болоогүй байна. Агаарын бохирдол, авто замын хөдөлгөөн, ахуйн хог хаягдлын асуудалдаа ч гарц олж амжаагүй байтал анхны барилгуудыг нураах цаг хаяанд хэдийнэ тулаад иржээ.

Тоон мэдээллээс харахад 1961 оноос өмнө 194, 1961-1974 онд 183 барилга Улаанбаатарт сүндэрлэсэн байдаг. Нийслэлийн хэмжээнд газар хөдлөлтөд тэсвэргүй, дахин төлөвлөж шинэчлэх шаардлагатай 325 орон сууцны барилга байгааг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас тогтоосон байдаг. Үүний хурээнд хуучны гэх тодотолтой 150 гаруй барилгыг яаралтай нурааж, шинэчлэх талаар ярьж эхэлсэн. Гэтэл монголчуудад барилга буулгах туршлага байхгүй аж. Ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн барилгыг буулгасан "Цамхаг констракшн" компанийн захирал Ц.Одгэрэл "Манай компанид Англид олон жил барилга буулгах ажил хийсэн нэг ажилтан бий. Түүний заавраар л сургуулийн барилгыг буулгасан даа.

▶5

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
839.97 0.28%	1251.30 0.20%	5834 0.41%	94.790 0.04%	99.980 0.04%	2421.28	350.50	42.20

Нийтлэлчийн булан

Төрийн тансаглалыг зогсоох шахалтыг баялаг бүтээгчид эхлүүлээ

Монгол хүн
эх орондоо
ажиллаж,
амьдрах боломж
олгооч



С.Батсайхан/ЗГМФ

Хэрэв даргын сэнтийд зарласан болгон албан өрөөгөө тохижуулж, унадаг тэргээ зарим нь шинээр солиогүй бол, гар утасныхаа төлбөрийг татвар төлөгчдөөр даалгаагүй бол төсвийн зардал дээрх хэмжээгээр нэмэгдэхгүй байсан. Төр худалдан авалтаа багасгаж, чадварлаг албан хаагчаар хүч сэлбэсэн бол төсвийн зардал тэгтлээ талийхгүй байв. Эдийн засгийн хүндрэлийн шуургад бага болон дундаж орлоготой иргэд туйлдаж гүйцлээ. Тэд шинээр бий болгох гэж буй татварын дарамтыг үүрч дийлэх эсэх нь эргэлзээтэй. Иргэд туйлдаж байна. Хувь хүний орлогын албан татвар болон Нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэх санаачилга гарсан хэрнээ захиргааны зардалд өөрчлөлт орсонгүй, харамсалтай нь.

Татвар нэмэх нь хамгийн хялбар аргаар тулгамдсан асуудлыг шийдэх гэсэн муйхар оролдлого байлаа. Үргүй зардлаа танах бус, татварын хувь хэмжээг нэмэх, тэтгэврийн насны босгыг өсгөх нь ард түмний хүсэл биш юм. Үүнийг хувийн хэвшлийнхэн эрс эсэргүүцэж байна. Хувь хүний орлогын албан татварыг шатлалтай болгох нь зөв. Гэхдээ одоогийн нөхцөлд цагаа олоогүй шийдвэр. Тиймээс татвар нэмэх бус, тансаглалаа зогсоох шахалтыг баялаг бүтээгчид илэрхийлж эхэллээ. Тэд төрд үгээ дайж, тэвчээр

алдарч байгаагаа зарлаж байна.

Эдийн засгийн хямралтай, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого буурсан ийм хүнд нөхцөлд Нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэх нь ажлын байр буурах, улмаар ядуурал ихсэх бодит шалтгааны нэг. Ингэж муйхарлахын оронд 10.8 их наяд төгрөгийн өр үйлдвэрлэсэн төрийн өмчит 80 гаруй компани, үйлдвэрийн газраа хувьчилж, татан буулгах асуудлыг эрх баригчид эхлүүлээсэй. Үүнийг хувийн хэвшлийнхэн хүсэж байна.

Төсвийн алдагдлыг нөхөхийн тулд Онцгой албан татварыг нэмэгдүүлчихвэл өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ дагаад

» Иргэн баян бол улс баян. Гэтэл үүний эсрэг Засгийн газар ажиллаж эхэллээ.

» Шатахууны онцгой албан татварыг өсгөхөөр төлөвлөж байгаа нь амьжиргааны өртөг зардлыг улам нэмэх бодит эрсдэлийн нэг.

» Тодотгол тодрох болсон шалтгаан нь иргэн болгоны халаасыг тэмтэрч байгаа болохоор, тэр.

өсөхөөр байна. Энэ нь иргэдэд үнийн өсөлт болж, хэтэвчийг нь торгоно гэсэн үг. Ялангуяа, шатахууны онцгой албан татварыг өсгөхөөр төлөвлөж байгаа нь амьжиргааны өртөг зардлыг улам нэмэх бодит эрсдэлийн нэг.

Засгийн газраас шатахууны жижиглэн борлуулалтын үнийг тогтворжуулах зорилгоор автобензин, дизель түлшний онцгой албан татварын хувь хэмжээг өнгөрсөн хугацаанд гурван ч удаа бууруулсан. Гэвч шатахууны үнэ буурах бус, эсрэгээрээ өссөн. Татвар буурахад үнэ өсгөдөг импортлогчид үнэ нэмлээ гэхэд хэвээр үлдээхгүй нь лавтай. Тэд татварын сураг ажиг хүлээж

байна. Энэ нь тэдний үнэ өсгөх маш том боломж юм. Харин иргэдийн хувьд гарз билээ.

Төсвийн тодотголын зургаар төр бүсээ чангалах бус, хувийн хэвшлийнхэн татварын дарамтын өмнө өвдөг сөгдөх нь. Улсын нэгдсэн төсвийн орлогыг санхүүжүүлэх боломж, гарц төрд бий. Үүнийг хүсэхгүй байгаа нь долоон татвараас тодорхой харагдана. Тавантолгой, Гацуурт зэрэг мега төслөө зөв хөдөлгөж чадвал 200 тэрбум төгрөгөөр төр үл дутна. Хавтгайрсан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг цэгцлэх цаг хэдийнэ болжээ. Үүнийг ажил болгосноор татварын орлого хамгийн багадаа хагас их наяд төгрөгөөр

бүрдэх боломжтой гэсэн судалгаа бий. Энэ боломжийг ашиглаж яагаад болохгүй гэж.

Төрийн өмчит компаниудын удирдлагад орлогоо нэмэгдүүлж, зардлаа хэмнэхийг даалгах хэрэгтэй. Тэд татвар төлөгчдийн мөнгөөр амар амгалан аж төрөх бус, улсад орлого бүрдүүлэхийн төлөө ажилладаг байх ёстой. Нэг нь үрдэг, нөгөө нь төлдөг байж таарахгүй. Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн орон. Зах зээлийн эдийн засагт төр давуу эрх эдэлнэ гэсэн философи байхгүй. Ийм хандлага ч үнэртэж болохгүй. Тиймээс төрийн албан хаагчдын шаардлагагүй зардал, нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмжийг зогсоох мэдэгдлийг Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Удирдах зөвлөл гаргасан. Үүнийг УИХ хүлээж авах, эсэх нь тодорхой бус байна.

Иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр болсон цалин, тэтгэмж 2012 оноос хойш дорвитой нэмэгдээгүй. Харин төгрөгийн худалдан авах чадвар үлэмж хэмжээгээр унасан. Ийм хатуу сорилттой нүүр тулгарсан иргэдэд төр татвараа нэмнэ гэж хэлэх нь хэтэрхий харгис бус уу. Монгол хүн хуримтлалтай "хориглож" байна. Төр л хамгийн том мөнгөний "авдар" хэвээр үлдэх гэсэн хүслээ эрх мэдэл болгохоор ахиулж байна. Татвараар дамжиж нийгмийн баялаг төрд төвлөрөх нь. Хувь хүний хадгаламжийн хүүгийн орлогоос татвар авах гэж байгаа нь үүнийг батална. Иргэн баян бол улс баян. Гэтэл УИХ маань үүний эсрэг хуулийг хэлэлцэх гэж байна. Монголоос мөнгө дайжих, монгол хүн эх орондоо ажиллах боломжгүй болтол нь төр татвараар дарамталж байна. [ЗГМ]

Шилдгүүдийг нэг дороос...



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИНЫ
2017 ОНЫ II УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА
ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.



УЛИРАЛД

44 ДУГААР

ЗАХИАЛГЫН ҮНЭ:
21,000₮



Блю Скай тауэр, 4 Давхар, № 407, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс, И-мэйл: info@zasag.co
Утас: +976 70103131, Факс: +976 70106065, Вэб: ubinfo.mn

Кино

ШИНЭ КИНО

“Галзуу хурд” эргэн ирнэ

Вин Дизель, Двайн Жонсон, Жэсон Стэтхэм, Мишель Родригез зэрэг Холливудын оддыг цуглуулсан “Галзуу хурд” киноны наймдугаар анги энэ сарын 14-нд нээлтээ хийнэ. Тус киноны зураг авалтын ихэнхийг АНУ-ын Нью-Йорк, Кубийн Гавана хотуудад хийжээ. Мөн Дубай, Рио де Жанейро хотуудаас гадна Ирландын байгалийн үзэсгэлэнт газруудыг кинодоо үзүүлэх юм байна.

“Галзуу хурд”-ын шинэ ангид гол дүр болох Домыг нэгэн үл таних эмэгтэй найз нарынхаа эсрэг ажиллахыг шаардсанаар үйл явдал эхэлдэг байна. Энэ ангид жүжигчин Дол Уолкерын дүү тоглоно хэмээн яригдаж байсан ч шинэ ангийн зохиолд багтаагүй бололтой. “Галзуу хурд”-ын багийнхан 2001 онд гарсан эхний ангиас хойш нийт дэлхийн зах зээлээс нийт 3.9 тэрбум ам.долларын ашиг олсон байна. [ЭГМ]

BOX OFFICE

“Хуягт сүнс” тэргүүлж чадсангүй



Жүжигчин Скарлет Йохансоны тоглосон “Хуягт сүнс” кино нээлтээ хийсэн даруйдаа дөнгөж 19 сая ам.долларын ашиг олж, кино багийнхны хүлээсэн үр дүнд хүрч чадсангүй. Тус киног бүтээхэд нийт 110 сая ам.доллар зарцуулсан учраас багагүй ашиг олно хэмээн найдаж байжээ. “Хуягт сүнс” кино нээлтээ хийснээс хойших 20 гаруй хоногт 62 сая ам.долларын орлого олсон байна. Өмнө нь жүжигчин Скарлет Йохансоны тоглосон “Люси” кино нээлтээ хийсэн эхний долоо хоногтоо л 43 сая ам.доллар олж байсан юм.

“Хуягт сүнс”-ийг Японы анимэйшнтэй төстэй, хийсвэр зураглал ихтэй хэмээн шүүмжилж байна. Энэ долоо хоногт тус кино “Вох office”-ийн жагсаалтад “Араатан ба гоо бүсгүй”, “Босс жаал”-ын араас тавдугаарт бичигджээ. [ЭГМ]

Дэлгэцийн урлагийн олон өнгө

Кино бүтээгчдийн анхаарал Хятадын зүг чиглэж байна

Б.Баярмаа @bayarmaaZGM

Энэтхэгийн Болливуд жилд үйлдвэрлэж буй киногоороо Холливудыг ардаа орхилоо. Үүнтэй зэрэгцэн Хятад үзэгчдийн тоо АНУ-ын араас хоёрт бичигдэж байна. Ийнхүү 120 гаруй жилийн настай кино ертөнцийн өнгө төрхийг Холливуд дангаараа тодорхойлохоо болиод удаж байна. Энэ удаа Холливудыг түр хойш нь тавиад дэлхийн кино зах зээлд өөрийн гэсэн байр суурийг эзэлж буй зарим орны талаар сонирхуулъя.

БОЛЛИВУД

Амьдралаас тэс хөндлөн, зөвхөн киноноос л харж болох “фантаазны” дүрслэлүүдээр дүүрэн энэтхэг кино тооны хүчээр дэлхийн кино зах зээлийг тэргүүлж байна. Хэдийгээр барууныхан Болливуд киног төдийлэн сонирхдоггүй ч дэлхийн хүн амын 17.5 хувь буюу 1.3 тэрбум энэтхэгчүүд тэдний үнэнч шүтэн бишрэгч. Тиймээс энэтхэг кино борлуулсан тасалбарынхаа тоогоор дэлхийд нэгдүгээрт бичигдэж байгаад гайхах зүйлгүй. Тус улсын кино зах зээлийн 55.4 хувийг дотоодынх нь кино эзэлдэг юм байна.

Энэтхэгийн кино урлаг 103 жилийн түүхтэй. Анх Английн колончлолын нөлөөгөөр кино урлаг үүссэн ч дуу хөгжим, өвөрмөц соёлоороо бусдаас онцгойрдөг юм. Тус улсын нийслэлийн хуучин нэр Бомбэйгээс улбаалан ийнхүү Болливуд гэж нэрлэх болжээ. Гэхдээ Мумбай хотод төвлөрдөг Болливудад энэтхэг киноны дөнгөж 20 хувийг хийдэг аж.

НОЛЛИВУД

Африк тивийн хамгийн их хүн амтай Нигери улс жилд хамгийн олон кино үйлдвэрлэдэг орнуудын хоёрдугаарт бичигддэг. Тус улс хөгжиж буй орны тоонд ордог. Энэ хэрээр 188 сая хүн ам нь кино урлаг хөгжих хөшүүрэг болдог аж. Нолливудын кино урлагаас “хар” тивийн соёл, зан заншил, үнэт зүйлс “үнэртдэг” учраас тус тивийн бусад оронд ч Нигерийн кино, жүжигчид алдартай байдаг. АНУ жилд дунджаар 819 кино бүтээж байхад



Барууныхан Болливуд киног төдийлэн сонирхдоггүй ч дэлхийн хүн амын 17.5 хувь буюу 1.3 тэрбум энэтхэгчүүд тэдний үнэнч шүтэн бишрэгч.

тус улс 997 буюу мянга орчмыг үйлдвэрлэдэг байна.

Нигери улс 1920-иод онд Английн колони байхад нутгийнханд зориулсан анхны кино гарч байжээ. Англичуудын үлдээсэн энэ өвийг нигеричүүд улам баяжуулж, газрын тос олборлож байсан 1950-1980 онд улам цэцэглүүлсэн байдаг. Энэ үеийг Нолливудын алтан үе гэж нэрлэдэг аж. Тэд энэ эрчээ алдалгүй явсаар 2000 оны эхээр дэлхийн хамгийн том кино үйлдвэрлэгч орнуудын тоонд багтсан байдаг.

ДАЛЛИВУД

Холливуд болон Бангладешийн нийслэл Дака хотын нэрийг оролцуулан ийнхүү Далливуд хэмээн нэрлэдэг. Бангладешийн уран бүтээлчид энэ зах зээлд хөл тавихдаа л уянгын драмаар танигджээ. Эдгээр киноноос дуу, бүжиггүй л болохоос энэтхэг киноны өнгө аяс мэдрэгддэг. Тус улсын Засгийн газраас зөвхөн кино урлагийг хөгжүүлэх, театруудыг тохижуулахад зориулан жилд нэг сая ам.доллар болон түүнээс илүү мөнгө зарцуулдаг юм байна. 168 сая хүн амтай тус улсад 100 гаруй кино компани байдаг аж.

ЛОЛЛИВУД

Пакистаны Пунжаб мужийн гол хот Лахор 1929-2007 он хүртэл тус улсын кино урлагийн төв байжээ. Тиймээс Лахор хотын нэрийг оролцуулан Лолливуд хэмээдэг аж. Хэдийгээр 2007

оноос хойш Пакистаны урлаг, соёлын төв нь Карачи болсон ч энэ нэр өөрчлөгдөөгүй юм.

1960-1980 онд ид цэцэглэж байсан ч тус улсын кино 2000 оны сүүлээр жилд дөнгөж хоёрхон кино гаргаж, зогсонги байдалд орсон гэж үздэг. Энэ хугацаанд тус улсын үзэгчид Болливудын киног шимтэн үзэх болжээ. Харин сүүлийн хоёр жилд эргэн сэргэж, жилд 20 гаруй кино бүтээж байгаа юм. Энэ нь тус улсын телевизүүд кино урлагт хөл тавьсантай холбоотой аж.

ХЯТАД

Сүүлийн жилүүдэд кино бүтээгчдийн анхаарал Холливудаас аажмаар холдож, Хятадын зүг чиглэж байна. Жилд хийдэг киноныхоо тоогоор гуравдугаарт, тасалбарын борлуулалтын тоогоор хоёрдугаарт жагсана гэдэг маш том үзүүлэлт. Кино шүүмжлэгчид ирэх таван жилд тус улсын кино зах зээл Энэтхэгийн байр суурийг эзэлж, дэлхийн хамгийн том кино үйлдвэрлэгч болно хэмээн таамаглаж буй.

Хонконг болон Тайванийн кино урлагийг нийтэд нь Хятадынх гэж үздэг. Хятадын кино урлагийн төв нь өнгөрсөн 100 гаруй жилийн туршид Шанхай хот байсаар ирсэн юм. Өдгөө тус улсын киноны орлогын 55 хувийг дотоодын уран бүтээлүүд эзэлдэг. Дэлхийн хамгийн олон хүн амтай улс учраас ашиг олох боломжтой гэж үзсэн гадныхан кино компаниудыг нь эзэмшиж эхлээд


буй.

ИРАН

Арилжааны зорилготой киноноос татгалздаг Ираны арт хаус төрлийн киногоор дэлхий нийт амьсгалж байна гэхэд буруудахгүй. Шүүмжлэгчид иран киног “тоо биш чанарт анхаарсан” гэж үнэлдэг. Сүүлийн 20 гаруй жил дэлхийн томоохон кино наадмуудыг Ираны тодотголтой бүтээлүүд эзэлж буй нь үүний баталгаа юм. Тус улсын кино театруудад Холливудын адал явдалт кино гарах нь өдрийн од шиг. Дотоодын арилжааны кинонууд зах зээлийг нэлэнхүйд нь эзэлдэг ч телевизээр албан ёсоор гарах нь тун ховор.

МОНГОЛ

Манай улсын хувьд жилд дунджаар 40 кино дэлгэцнээ гарч байна. Кино зах зээлийн 52 хувийг Холливудын адал явдалт кино эзэлж байгаа бол 39 хувь нь дотоодын уран бүтээл байдаг. Харин солонгос кино 4.7 хувийг эзэлдэг юм. Монгол үзэгчдийн дунд хамгийн эрэлттэй нь инээдмийн кино байдаг бөгөөд амжилттай кинонууд дунджаар 100 сая төгрөгийн ашиг олдог гэсэн тооцоо байна. Гэхдээ кино театрууд нийт ашгийн 45-50 хувийг авдаг нь уран бүтээлчдийн ахих боломжид тушаа болдог гэж үздэг билээ. [ЭГМ]



Шилдэг САНАА

Bloomberg TV Mongolia

Урлагийн ертөнцийн гоц авьяастнуудтай уулзуулдаг “Шилдэг санаа” нэвтрүүлгийн энэ удаагийн дугаарт Жауме Пленза оролцож байна. Тэрбээр олон нийтийн газруудад зориулсан хөшөө дурсгал бүтээдэг дэлхийн хамгийн алдартай уран барималчдын нэг юм. Түүний бүтээлүүд Риогоос Калгари, Нью-Йоркоос Токио хүртэл дэлхийн том хотуудын гудамж талбайг чимж байдаг. Тэрээр ган төмөр, шил, хүрэл, гэрэл, ус, бүр дуу авиан бүтээлүүдээрээ дамжуулан оршин буй орон зай, амьдарч буй газар нутгийнх нь талаарх хүмүүсийн ойлголтыг өөрчлөхийг зорьдог.

Баасан гараг /2017.04.14/

11:30

20:30 Бямба гараг

16:00 Ням гараг

Эдийн засаг

Хөрөнгө оруулалтын болomжуудыг танилцуулна

Хүн болгон хөрөнгө оруулагч байх тэрхүү бололцоог таниулахаар зорьж байна

Б.Мөнх ЗГМ

“Хөрөнгө оруулагч үндэстэн хаалттай хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Тамиртай энэ сарын 22-23-нд болох “Хөрөнгө оруулагч үндэстэн” чуулга уулзалтын талаар ярилцлаа. “Үндэсний хөрөнгө оруулагчдын хамгийн том чуулганы бэлтгэл ажил үргэлжилж байна” хэмээн тэрбээр тодотгосон юм.



С.Батсайхан / ЗГМ©

үргэлжилнэ.

“Хөрөнгө оруулагч үндэстэн” чуулганы бэлтгэл ажлаа хэр хангаж байна вэ?

Бидний зүгээс уг арга хэмжээг үндэсний хөрөнгө оруулагчдын хамгийн том чуулга уулзалт гэж онцолж байгаа. Чуулганы бэлтгэл ажил ид өрнөж байна. Олон нийтэд чуулгантай холбоотой мэдээллээ өнгөрсөн долоо хоногос түүгээг эхэлсэн. Чуулганд оролцохоор одоогийн байдлаар 400 гаруй хүн албан ёсоор бүртгүүлээд байна. Томоохон компани, гарааны бизнесүүд ивээн тэтгэгч болж, бидний ажлыг ихэд дэмжиж буй. Бүртгэл үргэлжилж байгаа. Чуулган бүтэн хоёр өдрийн турш үргэлжилнэ. Нэгдсэн болон салбар хуралдаанаар чуулган эхэлж, хэлэлцүүлэг, сургалт давхар болно. Харин дараагийн өдөр нь “Ард санхүүгийн нэгдэл” болон “Хөрөнгө оруулагч үндэстэн” компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар чуулган

Чуулганы нэр олон нийтийн анхаарлыг ихээхэн татаж байсан. Яагаад ингэж нэрлэх болов. Ямар нэг шалтгаан бий юу?

Ухаалгаар хуримтлалаа удирддаг хөрөнгө оруулагч үндэстэн бий болгох нь манай чуулга уулзалтын алсын хараа. Тиймээс чуулганаар хөрөнгө оруулалт, гарааны бизнес, санхүү болон технологи, хувьчлал гэсэн сэдэв анхаарлын төвд байх болно. Чуулганы нэртэй холбогдуулж зарим сэтгүүлч асууж байсан. Бидний хувьд шалтгаан маш тодорхой гэж ойлгож байгаа. Монгол хүн болгон хөрөнгө оруулагч байх тэрхүү боломж, бололцоог таниулахаар зорьж байна. Тиймээс “Хөрөнгө оруулагч үндэстэн” гэж чуулганаа нэрлэсэн.

Санхүүгийн зах зээл, ялангуяа хөрөнгийн зах зээлийн хөгжилд энэхүү чуулга уулзалт ямар эерэг нөлөө

Хөрөнгө оруулалт, гарааны бизнес, санхүү болон технологийн хувьчлал гэсэн сэдвийг өргөн хүрээнд хэлэлцэнэ.

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг идэвхжүүлэхэд тодорхой хувь нэмэр болохоос гадна иргэдэд санхүүгийн боловсрол олгоход түлхүү анхаарч байна.

Сайн жишээний тоонд “Монгол Шуудан” хувьцаат компанийн хувьчлал багтана.

зүүлэх вэ?

Бид Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг идэвхжүүлэхэд тодорхой хувь нэмэр болохоос гадна иргэдэд санхүүгийн боловсрол олгоход түлхүү анхаарч байна. Энэ хүрээнд тогтмол сургалт зохион байгуулж ирсэн. Чуулганы үеэр иргэдийн санхүүгийн боловсролд зориулсан номынхоо нээлтийг хийхээр төлөвлөж байгаа. Мөн санхүүжилт эрэлхийлж буй бизнесүүдийг хөрөнгө оруулагчидтай холбохоор зорьж байна. Чуулга уулзалтад гадаадын туршлагатай хөрөнгө оруулагчид ирж оролцно. Тэд өөрсдийн туршлагаа хуваалцаж, зах зээлийн чиг хандлагын талаар нээлттэй ярилцлага өрнүүлэх юм.

Чуулганаар ямар асуудлыг хэлэлцэхээр байгаа вэ?

Монголын эдийн засгийн байдал, санхүү, хөрөнгийн зах зээлийн өнөөгийн орчин нөхцөлийн талаар хэлэлцэнэ. Энэ


нь чуулганы хэлэлцэх асуудалд багтаж байгаа. Эдийн засаг дахь банк санхүү болон хөрөнгийн зах зээлийн тэнцвэртэй хөгжлийг бий болгох гарц, боломжийг чуулган эрэлхийлнэ. Түүнээс гадна хөрөнгө оруулалтын боломжуудыг оролцогчдоод танилцуулахад ач холбогдол өгч байгаа. Иргэдэд хөрөнгөө үр ашигтай удирдах арга ухааныг түгээх, тэр чиглэлийн туршлагаа оролцогчид хоорондоо солилцоно. Монголын компаниудыг дэлхийн цахим хувьсгалд бэлдэх шаардлагатай болж байна. Тиймээс “Санхүү ба технологи” гэсэн салбар хуралдаан болон хэлэлцүүлэг нь чуулганы онцлог хэсэг байх болно. Компани шинэ шатанд гарахад технологийн хөгжил, дэвшил чухал үүрэгтэй. Дэлхий нийтийн хандлага ч технологийн ололт руу чиглэж байна.

нийтийн санхүүгийн чөлөөт индэр байна. Чуулганы оролцогч хэлэлцүүлэг, илтгэл, мэдээлэл өгөх уулзалт, сургалт гээд энэ болгонд хамрагдах боломжтой. Бидний зүгээс тухайн хүний оролцоог хангах хүрээнд үр дүнтэй, ажил хэрэгч, бүтээлч байлгахад нь илүү анхаарч байгаа. Тухайлбал, хөрөнгийн зах зээл болон банкны системийн ялгаа, давуу, сул талуудын талаар иргэдэд тодорхой ойлголт өгөх шаардлагатай болж байна. Мөн хувийн санхүүгийн менежментийн цогц зөвлөгөөнөөс гадна энэ хүрээнд сургалт зохион байгуулахаар хөтөлбөрт тусгасан.

Чуулга уулзалтын онцлог сэдвийн нэг нь хувьчлал. Төрийн өмчит зарим компани засаглалын хямралаас эдийн засгийн хүндрэлд шилжсэн. Харин улсуудын тогтолцоо суларч, улмаар эдийн засгийн үр ашиг нь багассан. Тиймээс Засгийн газраас төрийн өмчит зарим аж ахуйн нэгжийг өнгөрсөн оноос хувьчилж эхэлсэн. Та хувьчлалын хамгийн ойрын сайн болон муу жишээ гэвэл юуг нэрлэх вэ?

Сайн жишээний тоонд “Монгол Шуудан” хувьцаат компанийн хувьчлал багтана. Тус компанийн 34 хувийг өнгөрсөн онд хөрөнгийн биржээр дамжуулан амжилттай хувьчилсан. Үүний үр дүнд компанийн үйл ажиллагаанд нь ахиц, дэвшил гарч, засаглалын чанар нь сайжирсан. Мөн өнгөрсөн онд алдагдлаа халж, нэг тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Хувьчлалыг хөрөнгийн биржээр дамжуулан зохион байгуулах нь илүү шударга, хүн болгонд нээлттэй. Муу жишээ гэвэл, “Улсын их дэлгүүр”. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгийн их зөрчиж байгаа. [ЗГМ]

Азийн хувьцааны зах зээлд уналт давамгайлал



MSE ALL индекс сүүлийн хоёр жилд (нэгжээр)

Table with columns: НЭР, СИМБОЛ, БИРЖ, ВАЛЮТ, ХАНШ, ӨӨРЧЛӨЛТ %, ОГНОО. Lists companies like RIO TINTO, WOLF PETROLEUM, etc.

Түүхий эд

Table with columns: НЭР, СИМБОЛ, НЭГЖ, ХАНШ (\$), ӨӨРЧЛӨЛТ %, ОГНОО. Lists commodities like ALTHNY SPOT, ЦАГААН АЛТ, МӨНГӨ, etc.

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.

АНУ-ын хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд сайжирч байгаа нь тус улсын төв банк мөнгөний бодлогоо үргэлжлүүлэн хумих магадлалыг өсгөөд байна. Үүнээс үүдэн Азийн хувьцаанууд унаж эхэллээ. Гэхдээ иенийн ханш унасан нь Японы хувьцаануудын ханшийг дэмжив. Тус улсын жишиг Торix индекс шинэ долоо хоногийн эхний өдөр 0.7 хувиар

дээшилсэн. Ингэснээр хоёр дахь өдрөө дараалан чангарав.

Харин Азийн тэргүүлэх эдийн засаг БНХАУ-ын Shanghai Composite индекс 0.5 хувиар доошиллоо. Мөн бүс нутгийн хүчирхэг улсуудын нэг БНСУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд унав. Өмнөд Солонгосын Kospi индекс 0.9 хувиар суларлаа. Тус индекс таван өдөр дараалан буураад байна. [ЗГМ]

Advertisement for 'ZASGIYN GAZRYN MEDEE' (Засгийн Газрын Мэдээ) featuring the text 'Танай компанийн мэдээлэл энд байрлаж болно' and phone numbers 99903584, 99903581.



Table with columns: НЭР, СИМБОЛ, ХАНШ (нэгж), ӨӨРЧЛӨЛТ %, ОГНОО. Lists market indicators like АПУ ХК, ГОВЬ ХК, МАХ ИМПЕКС ХК, etc.

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

Table with columns: НЭР, СИМБОЛ, ХАНШ (нэгж), ӨӨРЧЛӨЛТ, ӨӨРЧЛӨЛТ %, ОГНОО. Lists international indices like NASDAQ COMPOSITE, DAX INDEX, TORONTO STOCK EXCHANGE, etc.